



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/226

Мандалговь

「Аймгийн Цагдаагийн газрын орчинд цооног
өрөмдөх ажил хүлээлцэх комисс томилох тухай

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 11.4, 16.3 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй аймгийн Цагдаагийн газрын орчинд цооног өрөмдөх ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Д.Энхтуяа (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Х.Доржбямба (аймгийн Цагдаагийн газрын аж ахуйн ажилтан, цагдаагийн дэслэгч)

Гишүүд: Б.Цэрэнсугир (Байгаль, орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)
Т.Болд (аймгийн Цагдаагийн газрын нярав)
Н.Дашдорж (“Элбэг санчир” ХХК-ийн менежер, нягтлан)

Хоёр. Цооног өрөмдөх ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Д.Энхтуяа)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060830